



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/431

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222060

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08
дугаар сарын 26 - ны өдрийн 4431
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	"Авецина" ХХК-ийн эмнэлэг	287/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
2.	Эм Би Жи мед ХХК-ийн Эм Би Жи эмнэлэг	288/2022	2 жил	2022.08.28	2024.08.28
3.	БЗД, "Эрүүл өсөх" өрхийн эрүүл мэндийн төв	289/2022	4 жил	2022.08.31	2026.08.31
4.	СБД, "Энэр ази" өрхийн эрүүл мэндийн төв	290/2022	4 жил	2022.08.31	2026.08.31
5.	Архангай аймаг "Булган" сумын эрүүл мэндийн төв	291/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
6.	Архангай аймаг "Төвшрүүлэх" сумын эрүүл мэндийн төв	292/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
7.	Архангай аймаг "Цэнхэр" сумын эрүүл мэндийн төв	293/2022	3 жил	2022.08.31	2025.08.31
8.	Архангай аймаг "Ар манал" өрхийн эрүүл мэндийн төв	294/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
9.	Архангай аймаг "Ар мөнхжин" өрхийн эрүүл мэндийн төв	295/2022	3 жил	2022.08.31	2025.08.31
10.	Архангай аймаг "Ар мөнгөн чагнуур" өрхийн эрүүл мэндийн төв	296/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
11.	Баян-Өлгий аймаг "Толбо" сумын эрүүл мэндийн төв	297/2022	3 жил	2022.08.28	2025.08.28
12.	Говь-Алтай аймаг "Эрдэнэ" сумын эрүүл мэндийн төв	298/2022	3 жил	2022.09.01	2025.09.01
13.	Говь-Алтай аймаг "Баянтоорой" тосгоны эрүүл мэндийн төв	299/2022	2 жил	2022.09.01	2024.09.01
14.	Говь-Алтай "Жаргалан-Алтай" өрхийн эрүүл мэндийн төв	300/2022	3 жил	2022.09.07	2025.09.07
15.	Дундговь аймаг "Цагаандэлгэр" сумын эрүүл мэндийн төв	301/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
16.	Дундговь аймаг "Өндөршил" сумын эрүүл мэндийн төв	302/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
17.	Дундговь аймаг "Хулд" сумын эрүүл мэндийн төв	303/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
18.	Дундговь аймаг "Сайхан-Овоо" сумын эрүүл мэндийн төв	304/2022	3 жил	2022.08.31	2025.08.31
19.	Өмнөговь аймаг "Тэгш дүүрэн төгөлдөр" эмнэлэг	305/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
20.	Өмнөговь аймаг "Ханхонгор" сумын эрүүл мэндийн төв	306/2022	3 жил	2022.08.31	2025.08.31